



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 09 өдөр

Дугаар А/99.

Мандалговь.

Буцалтгүй тусламж үзүүлэх тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “г”, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, 7.1.3, 7.1.5, 7.1.6, Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 05 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дундговь аймгийн Сайнцагаан сумын иргэн Отгонсүрэн овогтой Үүрийнтуяа нь МУБИС-ийн 2 дугаар дамжаанд суралцдаг бөгөөд бүтэн өнчин, 2 дүүгийн хамт амьдардаг тул сургалтын төлбөрт нэг удаагийн буцалтгүй тусламжийг үзүүлсүгэй.

2. Буцалтгүй тусламжид 733.800 (долоон зуун гучин гурван мянга найман зуун) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

• 481210757